



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 01/19

Арвайхээр

Асран хамгаалагч тогтоох
тухай

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 71.1.1, 72.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүсэлт ирүүлсний дагуу 8 дугаар багийн иргэн Баярсайхан овогтой Мөнх-Эрдэнийн асран хамгаалагчаар Долгорсүрэн овогтой Уранчимэгийг тогтоосугай.

2. Асрамж дэмжлэгтээ байгаа хүнийг хоол хүнс, орон байраар хангах эрх ашиг сонирхлыг нь хамгаалах мөнгөн хөрөнгө үнэт зүйл, үнэт цаас бусад баримт бичгийг банкинд хадгалуулах, үл хөдлөх хөрөнгө, мал банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрсдөд нь зориулан зарцуулж, хүлээсэн үүргийнхээ талаар сумын Засаг даргад жил бүр тайлагнаж байхыг асран хамгаалагчид үүрэг болгосугай.

3. Асрамж дэмжлэгт байгаа хүнд хувийн хэрэг нээж асран хамгаалагчтай гэрээ байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сум хариуцсан Улсын бүртгэгч /Г.Шагдарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

14 0037